



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/АЗС

Булган сум

┌ Зургийн зөвлөхтэй гэрээ шууд байгуулах ┐
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.18 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/342 дугаар захирамжийн хавсралтын 34 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн 2026 оны төсвийн төсөөлөлд санал хүргүүлсэн төсөв шинэчлэх шаардлагатай аймгийн хөгжимт жүжгийн театрын барилгын ажлын зургийг 15,200,000 (арван таван сая хоёр зуун мянга) төгрөгөөр “Кон-инженерс” ХХК-тай, Булган сумын 6 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн шинэ барилгын ажлын зургийг 3,000,000 (гурван сая) төгрөгөөр “Энхийн жаргал констракшн” ХХК-тай, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын лабораторийн барилгын ажлын зургийг 6,800,000 (гурван сая найман зуун мянга) төгрөгөөр “Өлзий иш” ХХК-тай, Булган сумын 3 дугаар сургуулийн 110 хүүхдийн дотуур байрны ажлын зургийг 15,000,000 (арван таван сая) төгрөгөөр “Смарт прожект” ХХК-тай, Бизнес хөгжлийн төвийн барилгын ажлын зургийг 3,000,000 (гурван сая) төгрөгөөр төсөв шинэчлэхийг “Аслаан” ХХК-тай тус тус гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд төсөв шинэчилж, хүлээлгэн өгөхийг “Кон-инженерс” ХХК-ийн захирал (О.Зулаа), “Энхийн жаргал констракшн” ХХК-ийн захирал (Э.Ундармаа), “Өлзий иш” ХХК-ийн захирал (А.Ичинхорлоо), “Смарт прожект” ХХК-ийн захирал (С.Лхагвасүрэн), “Аслаан” ХХК-ийн захирал (Ж.Банзрай), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6335010691

Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажлын зургуудын төсөв шинэчлэх ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), Аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд) нарт даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал”-аас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР